



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС - PMI

2025.II
улирал

2025 оны 7 дугаар сар

МОНГОЛБАНК

Энэхүү үзүүлэлтийг олон улсад нийтлэг ашиглагддаг аргачлалын дагуу бодлого боловсруулагчид, бизнес эрхлэгчид болон олон нийтийн хэрэгцээнд зориулж улирлын давтамжтай тогтмол гаргаж байна.

1. Худалдан авалтын менежерийн индекс (PMI)

Ерөнхий индекс: Монгол Улсын худалдан авалтын менежерийн ерөнхий индексийн утга 2025 оны II улиралд өмнөх улирлаас 1.9 нэгжээр өссөнөөр агших мужаас тэлэлтийн мужид шилжиж **50.2** гарлаа. Ерөнхий индекс өмнөх улирлаас өсөхөд бараа материалын нөөц, шинэ захиалга, үйлдвэрлэлийн утга өссөн нь голлон нөлөөлөв (Зураг 1-2).


Нийлмэл индекс: Нийлмэл индексүүдийн хувьд бараа материалын нөөцийн индекс сүүлийн 10, ажил эрхлэлтийн индекс 7 улирал дараалан тэлэлтийн мужид гарлаа. Харин нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны индекс 18 улирал, үйлдвэрлэл, шинэ захиалгын индексийн утга тус тус 2 улирал дараалан агших мужид гарсан байна. Өмнөх улирлын үр дүнтэй харьцуулахад нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа, ажил эрхлэлтийн индекс бага зэрэг буурсан бол бусад үзүүлэлтүүд өсжээ (Зураг 2).

Салбарын индекс: 2025 оны II улиралд барилга, дотоод худалдаа, үйлчилгээний салбарын үзүүлэлтүүд агших мужид, аж үйлдвэрийн салбарын үзүүлэлт тэлэлтийн мужид хэвээр хадгалагдлаа. Тухайлбал, барилгын салбар сүүлийн 18, дотоод худалдааны салбар 4 улирал, үйлчилгээний салбар 2 улирал дараалан агших мужид, харин аж үйлдвэрийн салбар 5 улирал дараалан тэлэлтийн мужид гараад байна. Өмнөх улирлын утгатай харьцуулахад аж үйлдвэр 5.8, барилгын салбар 2.6, дотоод худалдаа салбар 1.6 нэгжээр тус тус нэмэгдсэн бол үйлчилгээний салбарын үзүүлэлт 3.2 нэгжээр буурчээ (Зураг 3).


Зураг 1. Ерөнхий индекс



Зураг 2. Нийлмэл индекс



Зураг 3. Ерөнхий индекс, салбараар



Үйлдвэрлэлийн индексийн утгыг эдийн засгийн өсөлттэй (бодит ДНБ-ий жилийн өөрчлөлт) харьцуулахад үйлдвэрлэлийн индексийн утга 50-аас их гарсан дийлэнх үеүдэд эдийн засаг өсөлттэй гарчээ. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэлийн индексийн утга нь бодит ДНБ-ий өсөлтийг тайлбарлах чадвар өндөр байна. Энэ улирлын үйлдвэрлэлийн индексийн утга 48.8 гарсан бөгөөд 2025 оны II улиралд эдийн засгийн өсөлт саарах төлөвтэй байна (Зураг 4).

Зураг 4. Бодит ДНБ-ий улирлын өөрчлөлт болон үйлдвэрлэлийн индекс




2. Салбарын үзүүлэлтүүд

Аж үйлдвэр: 2025 оны II улиралд салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт агших мужид, бусад үзүүлэлтүүд тэлэлтийн мужид гарсан байна. Өмнөх улирлын утгатай харьцуулахад бараа материалын нөөц 10.6, шинэ захиалга 9.8, үйлдвэрлэл 9.4, ажил эрхлэлт 3.3 нэгжээр өссөн бол, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 7.9 нэгжээр тус тус буурлаа (Зураг 5).

Аж үйлдвэрийн салбарын нэмэлт үзүүлэлтүүд бүгд тэлэлтийн мужид гарчээ. Өмнөх улиралтай харьцуулахад худалдан авалтын тоо хэмжээ 14.6, бизнесийн үйл ажиллагааны төлөв 4.0, дуусаагүй үйлдвэрлэл 2.4 нэгжээр тус тус өслөө. Харин бэлэн бүтээгдэхүүн 5.1, түүхий эд материалын үнэ 2.0, бүтээгдэхүүний үнэ 1.2 нэгжээр тус тус буурсан байна /Хүснэгт 1/.

Зураг 5. Аж үйлдвэрийн салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр



Хүснэгт 1. Аж үйлдвэрийн салбарын нэмэлт үзүүлэлтүүд


Үзүүлэлт	2024 III	2024 IV	2025 I	2025 II
Дуусаагүй үйлдвэрлэл	55.8↓	48.8↓	59.1↑	61.5↑
Бэлэн бүтээгдэхүүн	54.6↓	65.0↑	62.7↓	57.6↓
Бүтээгдэхүүний үнэ	56.9↓	66.6↑	71.4↑	70.2↓
Худалдан авалтын тоо хэмжээ	68.6↑	59.1↓	41.5↓	56.1↑
Түүхий эд, материалын үнэ	68.9↓	88.6↑	87.0↓	84.9↓
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	64.0↑	64.3↑	47.9↓	51.9↑

Барилга: Тайлант улиралд тус салбарын нийт үзүүлэлтүүдийн утга 2 улирал дараалан агших мужид гарсан байна. Харин өмнөх улирлын утгатай харьцуулбал бараа материалын нөөцийн үзүүлэлт 7.7, үйлдвэрлэлийн үзүүлэлт 6.1, ажил эрхлэлт 1.6, шинэ захиалга 0.6 нэгжээр тус тус өссөн бол нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт 1.5 нэгжээр буурчээ (Зураг 6).

Барилгын салбарын нэмэлт үзүүлэлтүүдийг авч үзвэл туслан гүйцэтгэгч ашиглалтын үзүүлэлт тэлэлтийн мужаас агших мужид шилжиж буурснаас гадна түүхий эд материалын үнийн үзүүлэлтээс бусад үзүүлэлтүүд агших мужид гарчээ. Өмнөх улирлаас түүхий эд материалын үнэ 2.5 нэгжээр өссөн бол худалдан авалтын тоо хэмжээ өөрчлөлтгүй гарсан байна. Харин орон сууцны зах зээлийн идэвхжил өмнөх улирлаас 10.7, туслан гүйцэтгэгч ашиглалт 8.2, барилга угсралтын үйл ажиллагаа 5.4, борлуулалтын үйл ажиллагаа 3.3 нэгжээр тус тус буурлаа /Хүснэгт 2/.

Дотоод худалдаа: 2025 оны II улиралд салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт тэлэлтийн мужид гарсан бол бусад үзүүлэлтүүд агших мужид гарлаа. Өмнөх улирлын утгатай харьцуулахад үйлдвэрлэл 11.0, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 3.2, шинэ захиалга 2.0 нэгжээр тус тус өссөн бол, харин ажил эрхлэлт 8.5 нэгж, бараа материалын нөөц 5.5 нэгжээр буурсан байна (Зураг 7).


Зураг 6. Барилгын салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр



Хүснэгт 2. Барилгын салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2024 III	2024 IV	2025 I	2025 II
Худалдан авалтын тоо хэмжээ	46.8↓	46.9↑	43.1↓	43.1
Түүхий эд, материалын үнэ	84.7↑	91.3↑	86.8↓	89.3↑
Орон сууцны зах зээлийн идэвхжил	46.8↓	41.4↓	49.2↑	38.5↓
Борлуулалтын үйл ажиллагаа	39.4↓	39.5↑	37.1↓	33.8↓
Барилга, угсралтын үйл ажиллагаа	48.7↓	40.7↓	39.9↓	34.5↓
Туслан гүйцэтгэгч ашиглалт	53.9↑	45.9↓	54.2↑	46.0↓
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	42.6↑	61.4↑	49.5↓	38.6↓

Зураг 7. Дотоод худалдааны салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр



Нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд хүлээгдэж буй борлуулалтын үзүүлэлтээс бусад 2 үзүүлэлт тэлэлтийн мужид гарчээ. Өмнөх улиралтай харьцуулахад худалдан авсан барааны хэмжээ 10.0, түүхий эд материалын үнэ 9.0 нэгжээр тус тус буурсан байна. Харин хүлээгдэж буй борлуулалтын үзүүлэлт өмнөх улирлаас 11.4 нэгжээр өссөн хэдий ч уг судалгаа эхэлснээс хойш 18 улирал дараалан агших мужид гарсан нь салбарын хүлээлт сайжрахгүй байгааг илтгэж байна /Хүснэгт 3/.


Үйлчилгээ: Салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа өөрчлөлтгүй гарсан бол шинэ захиалга, ажил эрхлэлтийн үзүүлэлт сүүлийн 3 улирал, үйлдвэрлэл (бизнесийн идэвхжил) сүүлийн 2 улирал дараалан агших мужид гарлаа. Өмнөх улирлын утгатай харьцуулахад ажил эрхлэлт 5.7, үйлдвэрлэл 5.3, шинэ захиалга 2.3 нэгжээр тус тус буурсан бол, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 1.6 нэгжээр өсжээ (Зураг 8).

Үйлчилгээний салбарын нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд бизнесийн үйл ажиллагааны төлөвийн үзүүлэлт агших мужид шилжиж буурсан бол бусад үзүүлэлтүүд тэлэлтийн мужид хэвээр гарлаа. Бизнесийн үйл ажиллагааны төлөвийн үзүүлэлт өмнөх улирлаас 5.7 нэгж, үйлчилгээний үнийн үзүүлэлт өмнөх улирлаас 1.6 нэгжээр тус тус буурсан бол, түүхий эд, материалын үнийн үзүүлэлт 5.2 нэгжээр өссөн байна. Харин дуусаагүй ажил үйлчилгээ өмнөх улирлаас өөрчлөгдөөгүй байна /Хүснэгт 4/.

Хүснэгт 3. Дотоод худалдааны салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2024 III	2024 IV	2025 I	2025 II
Түүхий эд, материалын үнэ	82.4↑	76.0↓	83.0↑	74.0↓
Худалдан авсан барааны хэмжээ	88.6↑	77.8↓	79.0↑	69.0↓
Хүлээгдэж буй борлуулалт	27.2↓	29.8↑	9.4↓	20.8↑

Зураг 8. Үйлчилгээний салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр



Хүснэгт 4. Үйлчилгээний салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2024 III	2024 IV	2025 I	2025 II
Түүхий эд, материалын үнэ	66.7↓	78.7↑	81.3↑	86.5↑
Үйлчилгээний үнэ	56.6↓	71.8↑	72.9↑	71.3↓
Дуусаагүй ажил үйлчилгээ	50.8↓	50.4↓	58.4↑	58.4
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	63.9↑	61.2↓	55.0↓	49.3↓


3. PMI индекс ААН-ийн ажиллагсдын тооны бүлгээр

Ажиллагсдын тооны бүлэг: Аж ахуйн нэгжүүдийг ажилчдын тоогоор жижиг (50 хүртэл), дунд (50-199), том (200-с дээш) гэж ангилан тайлант улирлын худалдан авалтын менежерийн индексийн утгыг тооцвол том ААН-үүдийн индексийн утга 13 улирал дараалан тэлэлтийн мужид, дунд ААН-үүдийн индексийн утга 2 улирал, жижиг ААН-үүдийн индексийн утга 18 улирал дараалан агших мужид гарлаа. Харин индексийн утгыг өмнөх улиралтай харьцуулахад жижиг ААН-үүд 2.2, дунд ААН-үүд 1.9 нэгжээр тус тус өсөж, харгалзан 41.6, 46.6-тай байлаа. Харин том ААН-үүдийн үзүүлэлт бага зэрэг буурч 52.4-тай гарлаа (Зураг 9).


Жижиг: ААН-үүдийн хувьд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт 9.2 нэгжээр буурсан ч тэлэлтийн мужид гарсан бол бусад бүх үзүүлэлт агших мужид гарсан байна. Өмнөх улиралтай харьцуулахад бараа материалын нөөц 6.9, үйлдвэрлэл 5.1, ажил эрхлэлт 4.8, шинэ захиалга 2.2 нэгжээр тус тус өссөн боловч агших мужид хэвээр гарлаа (Зураг 10).

Дунд: ААН-үүдийн хувьд энэ улиралд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа, бараа материалын нөөцийн үзүүлэлтээс бусад бүх үзүүлэлт агших мужид гарсан байна. Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт 5.4 нэгжээр өссөнөөр тэлэлтийн мужид шилжжээ. Өмнөх улирлын утгатай харьцуулахад шинэ захиалга 3.6, үйлдвэрлэл 2.9 нэгжээр өссөн бол, ажил эрхлэлт 3.3, бараа материалын нөөц 0.3 нэгжээр тус тус буурсан байна (Зураг 11).


Зураг 9. Байгууллагын хэмжээгээр



Зураг 10. Жижиг ААН-үүд, үзүүлэлтүүдээр




Зураг 11. Дунд ААН-үүд үзүүлэлтүүдээр




Том: ААН-үүдийн хувьд шинэ захиалга агших мужид шилжсэн бол ажил эрхлэлт сүүлийн 16, үйлдвэрлэл 13, бараа материалын нөөц 10 улирал дараалан тэлэлтийн мужид хэвээр гарлаа. Харин нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 2 улирал дараалан агших мужид гарсан байна. Өмнөх улирлын утгатай харьцуулахад бараа материалын нөөц 7.4, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 2.8 нэгжээр тус тус өссөн бол харин ажил эрхлэлт 6.1, үйлдвэрлэл 3.1, шинэ захиалга 2.4 нэгжээр тус тус буурчээ (Зураг 12)

Зураг 12. Том ААН-үүд үзүүлэлтүүдээр



4. Олон улсын PMI индекс

Зураг 13. Монгол болон худалдааны голлох түнш улсуудын PMI



Худалдааны голлох түнш улсуудын PMI¹: 2025 оны II улиралд манай худалдааны голлох түнш улсуудын PMI индекс өмнөх улирлаас бага зэрэг буурсан боловч ОХУ-ыг эс тооцвол бүгд тэлэлтийн мужид гарлаа. Тухайлбал, Евро бүсийн ерөнхий индексийн утга тэлэлтийн мужид 50.6 гарсан байна. Үйлдвэрлэл 6 сар дараалан, ажил эрхлэлт 4 сар дараалан өсжээ. Шинэ захиалгын бууралт саарч, сүүлийн 1 жилийн хугацааны хамгийн өндөр үзүүлэлтийг үзүүлсэн байна. БНХАУ-ын нийт бизнесийн идэвхжил нэмэгдэж 51.8 гарсан байна. Үүнд, үйлчилгээний салбараас илүүтэйгээр аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл хурдацтай өссөн нь голлон нөлөөлжээ. Экспорт багассан ч шинэ захиалга нэмэгдсэн байна. ОХУ-ын бизнесийн идэвхжил өмнөх улирлаас буурч 48.5 гарсан байна. Үүнд аж үйлдвэр, үйлчилгээний салбарын аль алинд үйлдвэрлэл буурсан нь нөлөөлжээ. Шинэ захиалга өнгөрсөн улирлаас буурснаас гадна, ажил эрхлэлт 2022 оны 12-р сараас хойших хамгийн хурдацтай буурсан

¹ Голлох түнш улсуудын PMI индексийн тухайн улирлын сүүлийн сарын үзүүлэлтээр тооцсон болно.

байна. Түүхий эд, үйлдвэрлэлийн зардал 2020 оны 7 сараас хойших хамгийн сул өсөлтийг үзүүлжээ. АНУ-ын PMI ерөнхий индекс 52.9 гарсан бөгөөд бизнесийн идэвхжил тогтвортой өсөлттэй байна. Шинэ захиалга, үнэ нэмэгдэж байгаагаас гадна ажил эрхлэлт сүүлийн 5 сарын хамгийн хурдацтай өсөлтийг үзүүлсэн байна. 2025 оны II улиралд дэлхийн PMI ерөнхий индекс 51.7 гарсан бөгөөд сүүлийн 2 жил хагасын туршид тэлэлтийн мужид байна. Үйлдвэрлэл, шинэ захиалга, ажил эрхлэлт хурдацтай өсжээ. Харин түүхий эдийн үнэ, бүтээгдэхүүний үнэ буурсан байна.

ААН-ийн ерөнхий мэдээлэл

Судалгааны түүвэрлэлт хийхдээ аж үйлдвэр, барилга, дотоод худалдаа (бөөний болон жижиглэн) болон үйлчилгээний салбаруудаас идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй, эх олонлогийг төлөөлөхүйц 402 ААН-ийг **жижиг** (49 хүртэл ажилтантай), **дунд** (50-199 хүртэл ажилтантай), **том** (200-с дээш ажилтантай) гэж ангилан түүвэрлэлт хийсэн бөгөөд ингэхдээ тухайн ангилалд хамаарах бүх аж ахуйн нэгжүүдээс жилийн борлуулалтын орлогоор тэргүүлэх аж ахуйн нэгжүүдийг түүвэрт сонголоо.

Судалгааны асуулгыг **2025 оны 6, 7-р сард нийт 402** аж ахуйн нэгжийн дунд явуулсан бөгөөд **аж үйлдвэрийн салбарын 132, барилгын салбарын 68, дотоод худалдааны салбарын 68, үйлчилгээний салбарын 134** аж ахуйн нэгжүүд судалгаанд хамрагдлаа. Ажилчдын тоогоор жижиг ангилалд хамаарах 284 (71%), дунд 84 (21%), том 34 (8%) аж ахуйн нэгжүүд судалгаанд оролцлоо /Хүснэгт 1/.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн тоо, салбар, ажилтны тооны бүлгээр²

Ерөнхий салбар	Салбар	ААН-ийн тоо 2025.II*	Жижиг	Дунд	Том	Нийт	Эзлэх хувь
Аж үйлдвэр (132)	Уул уурхай, олборлолт	1,219	7	6	5	18	4%
	Боловсруулах үйлдвэрлэл	7,900	71	18	8	97	24%
	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	295	4	4	2	10	2%
	Усан хангамж	244	5	-	2	7	2%
Барилга	Барилга	8,611	54	12	2	68	17%
Дотоод худалдаа	Бөөний болон жижиглэн худалдаа	42,478	51	11	6	68	17%
Үйлчилгээ (134)	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	4,216	11	4	1	16	4%
	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	3,071	9	4	1	14	3%
	Мэдээлэл, холбоо	3,127	5	2	-	7	2%
	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2,091	2	4	2	8	2%
	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1,281	6	2	1	9	2%
	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн ү.а	6,891	8	-	-	8	2%
	Боловсрол	3,931	1	2	1	4	1%
	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	2,866	13	7	1	21	5%
	Урлаг, үзвэр, тоглоом наадам	1,199	-	-	1	1	0%
	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	9,477	37	8	1	46	11%
Нийт		98,897	284	84	34	402	100%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

² 2025 оны II улирлын байдлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн тоо

Жилийн борлуулалтын орлогоор ангилан авч үзвэл 50 хүртэл сая төгрөгийн 21 (5%), 50-300 сая төгрөгийн 56 (14%), 300 саяас 1 тэрбум төгрөгийн 67 (17%), 1-2.5 тэрбум төгрөгийн 66 (16%), 2.5-с дээш тэрбум төгрөгийн орлоготой 192 (48%) аж ахуйн нэгж судалгаанд хамрагджээ /Хүснэгт 2/.

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн тоо, салбар, жилийн борлуулалтын орлогын бүлгээр

Ерөнхий салбар	Салбар	Жижиг	Дунд	Том	Нийт	Эзлэх хувь
Аж үйлдвэр	50 сая₮ хүртэл	9			9	2%
	50-300 сая₮ хүртэл	16			16	4%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	24	1		25	6%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	12	1		13	3%
	2.5 тэрбум₮ дээш	26	26	17	69	17%
Барилга	50 сая₮ хүртэл	2			2	0%
	50-300 сая₮ хүртэл	7			7	2%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	2	1		3	1%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	20			20	5%
	2.5 тэрбум₮ дээш	23	11	2	36	9%
Дотоод худалдаа	50 сая₮ хүртэл	3			3	1%
	50-300 сая₮ хүртэл	11			11	3%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	15			15	4%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	9	1		10	2%
	2.5 тэрбум₮ дээш	13	10	6	29	7%
Үйлчилгээ	50 сая₮ хүртэл	7			7	2%
	50-300 сая₮ хүртэл	21	1		22	5%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	23	1		24	6%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	19	4		23	6%
	2.5 тэрбум₮ дээш	22	27	9	58	14%
Нийт	50 сая₮ хүртэл	21	-	-	21	5%
	50-300 сая₮ хүртэл	55	1	-	56	14%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	64	3	-	67	17%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	60	6	-	66	16%
	2.5 тэрбум₮ дээш	84	74	34	192	48%
Нийт		284	84	34	402	100%

Худалдан авалтын менежерийн индексийн тухай

Худалдан авалтын менежерийн индекс (PMI) нь бодлого боловсруулагчид, хөрөнгө оруулагчид болон аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудын хувьд эдийн засаг, бизнесийн төлөв байдлыг харах, үйл ажиллагаагаа удирдах, төлөвлөх, урьдчилан таамаглах, шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой үзүүлэлт болдог. PMI нь тооцоход хялбар энгийн аргачлал дээр үндэслэгдэж, албан ёсны статистик тоон мэдээлэл гарахаас өмнө эдийн засаг, бизнесийн төлөв байдлыг тодорхойлохын зэрэгцээ бусад орнуудтай харьцуулалт хийх боломж олгодгоороо давуу талтай. Олон улсын туршлагаас харахад уг индексийг тооцохдоо эдийн засгийн голлох салбаруудын нөлөө бүхий 400 орчим аж ахуйн нэгжүүдийг сонгон түүвэрлэлтэд хамруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, шинэ захиалга, ажил эрхлэлт, бараа материалын нөөц, хүргэлтийн хугацаа болон бусад үзүүлэлтийн талаарх мэдээллийг судалж, эдгээр үзүүлэлт бүрээр индексийн утгыг тооцон, индексийн өөрчлөлтийг харгалзан дүгнэлт өгдөг.

“Худалдан авалтын менежерийн индекс (Purchasing manager index-PMI)” нь эдийн засгийн ерөнхий хандлагыг харуулсан чиглэлийн индекс юм.

Аргачлал: Түүвэр судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс үзүүлэлт тус бүрийн хувьд өмнөх улирлаас хэрхэн өөрчлөгдсөн талаар чанарын асуулт асууж, хариултуудыг нэгтгэх замаар тоон буюу индексийн утгад шилжүүлнэ. Индексийг үзүүлэлт тус бүрээр тооцон гаргаж салбаруудын индекс, нийлмэл индекс, нийт эдийн засгийн индексийг тооцоолоход ашиглана.

$$\text{PMI (тухайн үзүүлэлтийн тархалтын индекс)} = (K1 * 1) + (K2 * 0.5) + (K3 * 0)$$

$k1$ = Өссөн гэсэн хариултын хувь

$k2$ = Хэвэндээ гэсэн хариултын хувь

$k3$ = Буурсан гэсэн хариултын хувь

Уг индексийн тооцоолсон утгыг **тархалтын индекс** гэж нэрлэх бөгөөд PMI=50 бол бизнесийн үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүйг, PMI>50 бол бизнесийн үйл ажиллагааны тэлэлтийг, PMI<50 бол агшилтыг тус тус илэрхийлдэг. Энэхүү утга 50-аас холдох тусам тэлэлт эсвэл агшилт ихэснэ. Тодруулбал, PMI-ийн үзүүлэлт өмнөх улирлын үзүүлэлтээс өндөр байвал эдийн засаг илүү хурдтай тэлж (агшиж) байгааг, харин өмнөх улирлаас доогуур байвал илүү багаар тэлж (агшиж) байна гэсэн утгыг илэрхийлнэ.

Энэхүү судалгаанд PMI-ийг эдийн засгийн голлох салбаруудаар тооцохын зэрэгцээ аж ахуйн нэгжийн ажилчдын тоог нь харгалзан жижиг (49 хүртэл), дунд (50-199), том (200-с дээш) гэж ангилан, бүлэг тус бүрээр индексийг тооцож гаргасан. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлогын нийт борлуулалтын орлогод эзлэх хувиар нь бүлэг тус бүрийн үзүүлэлтийн тархалтын индексийг жигнэж тухайн үзүүлэлтийн салбар бүр дэх индексийн утгыг тооцлоо. Салбар болон нийт эдийн засгийн PMI-ийг тооцохдоо гол үзүүлэлтүүдийн нийлмэл³ индексийг олон улсад нийтлэг ашиглагддаг ач холбогдлын жингээр⁴ жигнэн тооцсон болно.

³ Салбар бүр дэх гол 5 үзүүлэлтүүдийн индексийг ДНБ-д эзлэх хувиар жигнэн тооцсон үзүүлэлт болно.

⁴ Олон улсын туршлагаар PMI-ийг тооцохдоо шинэ захиалга 30%, үйлдвэрлэлийн хэмжээ 25%, ажил эрхлэлт 20%, нийлүүлэлт хугацаа 15%, бараа материалын нөөц 10%-иар жигнэж тооцдог байна. An introduction to the PMI surveys, IHS Markit.

Аж үйлдвэр

Үзүүлэлт	2023.I	2023.II	2023.III	2023.IV	2024.I	2024.II	2024.III	2024.IV	2025.I	2025.II
Аж үйлдвэр	53.1	57.9	57.0	60.4	49.2	56.3	61.7	61.8	50.8	56.7
Шинэ захиалга	47.3	61.4	61.7	61.9	43.7	52.9	62.3	59.6	42.3	52.1
Үйлдвэрлэл	53.7	64.2	60.4	65.8	45.7	66.2	70.7	67.8	49.1	58.5
Ажил эрхлэлт	57.4	52.1	53.5	66.8	57.9	55.6	65.8	63.0	63.4	66.7
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	53.9	46.2	47.6	44.1	45.2	45.0	37.1	48.6	48.2	40.3
Түүхий эд, материалын нөөц	58.9	61.3	55.5	53.7	62.5	59.9	66.4	70.3	59.8	70.4
Жижиг										
Шинэ захиалга	41.1	52.1	44.7	43.7	48.8	44.0	49.4	42.5	38.0	38.0
Үйлдвэрлэл	42.1	49.3	50.0	44.1	47.6	42.2	51.3	48.9	34.4	36.6
Ажил эрхлэлт	41.4	39.7	41.1	42.3	47.6	41.2	51.9	49.0	37.8	45.9
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	52.6	58.8	50.6	50.0	53.1	41.7	39.3	52.8	57.4	46.2
Түүхий эд, материалын нөөц	42.0	43.1	51.3	46.7	48.0	48.0	57.9	55.7	39.2	47.1
Дуусаагүй үйлдвэрлэл	51.3	54.4	51.7	48.1	48.5	48.9	54.6	53.2	47.0	58.5
Бэлэн бүтээгдэхүүн	43.9	50.0	54.7	46.7	50.7	47.0	54.7	46.0	40.6	42.3
Бүтээгдэхүүний үнэ	72.2	69.1	68.8	64.9	60.2	62.7	71.4	70.3	68.3	69.4
Худалдан авалтын тоо хэмжээ	39.9	46.7	46.7	49.4	43.5	39.0	52.6	45.5	34.7	39.2
Түүхий эд, материалын үнэ	85.8	84.5	79.6	80.4	72.9	76.0	86.2	85.3	85.2	85.3
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	57.1	51.5	51.7	50.6	43.5	52.1	54.1	58.4	44.1	50.0
Дунд										
Шинэ захиалга	51.0	53.4	58.6	63.6	60.0	48.0	42.9	43.8	41.3	44.4
Үйлдвэрлэл	53.9	62.1	56.7	71.2	58.1	60.4	55.0	48.1	42.0	48.2
Ажил эрхлэлт	52.9	43.1	41.1	60.0	58.5	54.0	40.9	53.8	44.2	51.8
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	43.9	43.1	46.6	46.9	46.4	36.0	47.5	50.0	45.8	50.0
Түүхий эд, материалын нөөц	50.0	59.1	53.7	54.5	55.3	46.0	38.1	52.0	44.0	50.0
Дуусаагүй үйлдвэрлэл	46.7	62.1	64.3	63.6	55.3	60.4	65.0	52.2	42.9	54.0
Бэлэн бүтээгдэхүүн	55.1	52.3	51.9	51.6	59.2	58.0	54.8	52.0	46.0	41.7
Бүтээгдэхүүний үнэ	79.4	71.7	63.3	69.7	68.3	66.0	54.8	71.2	72.0	60.7
Худалдан авалтын тоо хэмжээ	50.0	47.8	64.8	56.1	51.2	50.0	50.0	56.0	42.0	54.0
Түүхий эд, материалын үнэ	93.0	86.7	77.6	87.1	79.1	76.0	78.6	84.6	86.0	82.1
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	63.0	52.2	63.8	51.5	51.2	56.3	60.5	52.0	60.4	48.2
Том										
Шинэ захиалга	47.9	64.7	65.8	65.4	40.0	55.6	68.2	65.8	43.3	56.3
Үйлдвэрлэл	56.0	67.6	63.2	69.2	43.3	72.2	77.3	75.0	53.3	64.7
Ажил эрхлэлт	61.5	56.3	58.3	73.1	60.0	58.8	72.7	67.5	71.9	73.5
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	56.0	44.1	47.2	42.3	43.3	47.2	35.0	47.5	46.7	37.5
Түүхий эд, материалын нөөц	64.0	65.4	56.7	55.0	66.7	64.7	72.7	76.3	66.7	78.6
Дуусаагүй үйлдвэрлэл	52.2	64.7	61.1	61.5	46.4	62.5	54.5	47.4	64.3	63.3
Бэлэн бүтээгдэхүүн	65.4	61.5	66.7	55.0	56.7	67.6	54.5	71.1	70.0	63.3
Бүтээгдэхүүний үнэ	80.0	61.8	69.4	69.2	66.7	58.3	54.2	65.0	71.9	71.9
Худалдан авалтын тоо хэмжээ	53.8	53.6	73.3	60.0	40.0	66.7	75.0	62.5	42.9	60.0
Түүхий эд, материалын үнэ	86.5	82.4	89.5	80.8	80.0	82.4	63.6	90.0	87.5	85.3
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	53.8	53.1	50.0	88.5	40.0	61.1	66.7	67.5	46.7	52.9

Барилга

Үзүүлэлт	2023.I	2023.II	2023.III	2023.IV	2024.I	2024.II	2024.III	2024.IV	2025.I	2025.II
Барилга	45.3	46.2	38.3	41.5	45.6	47.5	45.0	45.4	38.6	41.2
Шинэ захиалга	38.8	47.0	35.2	30.9	39.2	43.0	40.6	46.2	34.1	34.7
Үйлдвэрлэл	46.1	45.6	38.2	43.6	50.9	58.2	54.9	44.4	33.6	39.6
Ажил эрхлэлт	49.3	44.0	29.6	46.0	47.2	44.3	41.9	40.8	44.2	45.8
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	52.8	52.7	47.4	56.1	50.6	46.6	48.4	53.3	48.1	46.6
Түүхий эд, материалын нөөц	43.1	39.7	51.4	37.3	40.5	42.0	34.5	42.5	39.8	47.5
Жижиг										
Шинэ захиалга	39.3	40.9	34.2	35.9	40.1	48.1	45.8	45.4	39.7	40.0
Үйлдвэрлэл	47.5	43.4	34.4	44.9	48.2	57.1	52.0	42.9	42.3	47.2
Ажил эрхлэлт	41.1	34.8	25.0	46.8	45.1	39.7	43.8	36.6	45.5	46.3
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	54.5	52.8	48.0	56.8	52.1	44.0	45.6	53.8	50.0	52.0
Түүхий эд, материалын нөөц	38.6	35.4	50.7	39.1	40.8	46.4	38.0	45.4	44.5	50.0
Худалдан авалтын тоо хэмжээ	42.2	38.6	39.2	44.9	44.9	48.1	51.1	50.0	41.3	41.2
Түүхий эд, материалын үнэ	89.8	88.1	89.4	85.6	82.9	79.6	77.7	89.1	83.3	86.8
Орон сууцны зах зээлийн идэвхжил	33.3	43.1	31.5	39.0	50.7	52.2	51.1	45.5	53.1	36.8
Борлуулалтын үйл ажиллагаа	67.8	37.7	35.2	41.1	38.4	42.0	45.7	41.5	39.3	39.6
Барилга, уесралтын үйл ажиллагаа	41.2	40.8	47.4	39.9	46.0	57.7	51.0	44.2	47.5	37.0
Туслан гүйцэтгэгч ашиглалт	47.1	46.9	46.0	50.9	42.3	50.0	45.7	46.9	49.1	42.0
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	53.3	56.4	59.9	53.8	49.3	39.7	45.7	63.7	53.3	40.4
Дунд										
Шинэ захиалга	42.9	56.3	29.2	27.8	30.0	30.8	31.3	46.9	20.0	36.4
Үйлдвэрлэл	50.0	44.0	41.7	48.2	52.3	57.1	38.9	46.7	22.7	36.4
Ажил эрхлэлт	62.0	48.1	34.0	41.4	50.0	57.1	45.0	50.0	36.4	41.7
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	54.0	54.0	54.3	57.7	42.9	53.6	57.1	53.6	54.5	54.5
Түүхий эд, материалын нөөц	56.0	45.8	54.3	30.8	34.2	26.9	27.8	28.1	31.8	37.5
Худалдан авалтын тоо хэмжээ	52.0	43.8	45.7	51.9	41.3	58.3	44.4	34.4	45.5	45.8
Түүхий эд, материалын үнэ	92.0	90.4	88.6	91.1	86.4	75.0	100.0	93.8	90.9	91.7
Орон сууцны зах зээлийн идэвхжил	35.3	41.7	35.7	30.0	32.4	57.1	30.0	36.7	35.0	37.5
Борлуулалтын үйл ажиллагаа	73.1	36.7	44.4	37.5	36.8	42.3	40.0	26.7	36.4	33.3
Барилга, уесралтын үйл ажиллагаа	58.8	41.7	39.6	39.7	44.4	50.0	40.0	37.5	36.4	45.8
Туслан гүйцэтгэгч ашиглалт	50.0	30.8	37.5	56.8	50.0	57.1	55.6	40.0	45.5	57.1
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	53.8	54.0	43.5	48.1	52.5	45.8	56.3	60.0	45.5	54.2
Том										
Шинэ захиалга	30.0	60.0	50.0	12.5	50.0	33.3	25.0	50.0	25.0	50.0
Үйлдвэрлэл	33.3	58.3	50.0	30.0	65.0	66.7	100.0	50.0	0.0	50.0
Ажил эрхлэлт	66.7	80.0	43.8	50.0	55.0	50.0	25.0	50.0	50.0	50.0
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	42.9	50.0	33.3	50.0	55.0	50.0	50.0	50.0	25.0	50.0
Түүхий эд, материалын нөөц	42.9	50.0	50.0	40.0	50.0	41.7	25.0	50.0	25.0	50.0
Худалдан авалтын тоо хэмжээ	33.3	50.0	50.0	50.0	55.0	41.7	25.0	50.0	50.0	50.0
Түүхий эд, материалын үнэ	100.0	75.0	75.0	80.0	77.8	66.7	100.0	100.0	100.0	100.0
Орон сууцны зах зээлийн идэвхжил	50.0	50.0	83.3	10.0	60.0	70.0	50.0	25.0	50.0	50.0
Борлуулалтын үйл ажиллагаа	78.6	50.0	42.9	30.0	44.4	50.0	0.0	50.0	25.0	50.0
Барилга, уесралтын үйл ажиллагаа	25.0	66.7	62.5	40.0	60.0	41.7	50.0	25.0	0.0	50.0
Туслан гүйцэтгэгч ашиглалт	50.0	60.0	50.0	40.0	62.5	58.3	100.0	50.0	100.0	50.0
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	62.5	58.3	37.5	40.0	55.6	41.7	0.0	50.0	33.3	50.0

Дотоод худалдаа

Үзүүлэлт	2023.I	2023.II	2023.III	2023.IV	2024.I	2024.II	2024.III	2024.IV	2025.I	2025.II
Дотоод худалдаа	53.6	50.5	53.2	51.0	50.2	53.7	49.3	49.6	40.9	42.5
Шинэ захиалга	51.8	51.6	57.0	49.2	48.1	54.8	50.8	52.1	31.9	33.9
Үйлдвэрлэл	62.9	65.1	62.6	54.1	50.7	65.7	55.5	48.8	30.6	41.6
Ажил эрхлэлт	51.3	40.9	44.0	52.2	52.1	49.7	45.7	47.0	51.1	42.6
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	44.8	36.3	45.5	52.6	43.2	42.3	43.1	50.7	53.3	56.5
Түүхий эд, материалын нөөц	53.6	50.9	48.4	43.7	61.9	45.1	45.8	47.8	54.9	49.4
Жижиг										
Шинэ захиалга	46.5	45.8	48.1	48.0	40.9	51.3	42.5	41.2	32.0	38.5
Үйлдвэрлэл	50.7	54.3	57.9	53.2	42.5	56.4	44.3	39.0	27.5	46.1
Ажил эрхлэлт	40.8	39.6	43.2	46.8	46.9	43.8	49.1	39.8	45.2	40.2
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	46.9	45.7	46.9	52.1	53.9	41.3	47.0	50.0	61.7	52.1
Түүхий эд, материалын нөөц	44.8	40.7	47.0	37.9	54.5	47.5	43.6	38.0	36.2	40.0
Худалдан авсан барааны дундаж үнэ	81.9	79.2	76.8	81.9	69.2	73.8	80.2	70.2	74.0	74.5
Худалдан авсан барааны хэмжээ	88.4	54.3	74.6	66.9	70.7	78.8	82.4	69.0	69.1	67.7
Хүлээгдэж буй борлуулалт	26.3	33.0	36.9	32.7	35.5	30.0	16.7	24.6	16.3	24.5
Дунд										
Шинэ захиалга	54.5	53.8	61.5	42.3	56.0	69.2	50.0	59.1	30.0	44.4
Үйлдвэрлэл	69.2	59.1	67.9	42.3	54.0	65.4	66.7	50.0	36.4	45.5
Ажил эрхлэлт	65.4	42.3	46.7	57.7	52.1	65.4	44.4	63.6	68.2	50.0
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	50.0	31.8	38.5	38.5	27.1	45.8	50.0	40.9	50.0	65.0
Түүхий эд, материалын нөөц	62.5	62.5	50.0	62.5	77.1	50.0	72.2	60.0	77.8	54.5
Худалдан авсан барааны дундаж үнэ	72.7	73.1	90.0	82.1	80.0	70.8	83.3	68.2	90.9	80.0
Худалдан авсан барааны хэмжээ	90.9	77.3	86.4	87.5	82.0	76.9	94.4	80.0	85.0	75.0
Хүлээгдэж буй борлуулалт	34.6	34.6	33.3	29.2	27.1	23.1	33.3	36.4	0.0	22.7
Том										
Шинэ захиалга	62.5	64.3	75.0	60.0	60.0	50.0	75.0	75.0	33.3	10.0
Үйлдвэрлэл	87.5	100.0	68.8	70.0	70.0	91.7	75.0	75.0	33.3	25.0
Ажил эрхлэлт	62.5	42.9	42.9	60.0	66.7	50.0	37.5	50.0	50.0	41.7
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	33.3	16.7	50.0	70.0	30.0	41.7	25.0	62.5	33.3	60.0
Түүхий эд, материалын нөөц	66.7	64.3	50.0	37.5	66.7	33.3	25.0	62.5	83.3	70.0
Худалдан авсан барааны дундаж үнэ	62.5	50.0	100.0	90.0	80.0	66.7	87.5	100.0	100.0	66.7
Худалдан авсан барааны хэмжээ	75.0	64.3	85.7	50.0	90.0	75.0	100.0	100.0	100.0	66.7
Хүлээгдэж буй борлуулалт	50.0	64.3	56.3	50.0	20.0	33.3	50.0	37.5	0.0	8.3

Үйлчилгээ

Үзүүлэлт	2023.I	2023.II	2023.III	2023.IV	2024.I	2024.II	2024.III	2024.IV	2025.I	2025.II
Үйлчилгээ	52.0	52.3	51.4	56.0	52.9	52.3	55.6	50.4	48.0	44.8
Шинэ захиалга	49.9	53.0	50.4	58.6	55.5	52.9	53.4	48.2	48.2	46.0
Борлуулалтын орлого	60.2	57.3	59.1	57.9	55.9	57.8	63.9	57.1	47.2	41.9
Ажил эрхлэлт	52.5	48.8	43.5	54.0	49.7	52.9	54.3	47.9	48.5	42.8
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	42.6	47.5	51.3	51.0	47.3	41.7	48.5	47.0	48.4	50.0
Жижиг										
Шинэ захиалга	46.2	49.6	44.9	45.9	51.0	38.4	42.3	40.0	33.0	36.3
Борлуулалтын орлого	50.0	53.3	50.7	54.0	50.0	40.9	45.8	44.9	30.3	34.3
Ажил эрхлэлт	40.1	42.5	42.9	48.0	49.5	43.9	38.9	45.5	38.7	43.4
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	51.4	49.2	49.1	46.4	49.4	40.4	53.0	47.5	63.7	55.6
Түүхий эд, материалын үнэ	85.0	87.0	81.5	76.8	77.3	72.5	75.8	81.8	81.8	83.8
Үйлчилгээний үнэ	68.5	67.9	64.2	63.5	63.9	64.3	70.7	69.2	68.1	67.8
Дуусаагүй ажил үйлчилгээ	55.1	71.8	44.8	68.0	56.1	60.6	60.0	53.2	56.3	52.8
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	59.9	51.7	52.8	46.2	56.3	42.6	50.0	54.1	45.6	40.0
Дунд										
Шинэ захиалга	45.3	60.3	54.8	57.5	52.3	58.9	51.9	48.5	45.6	45.2
Борлуулалтын орлого	51.4	60.3	53.6	58.3	65.1	69.1	64.8	60.0	45.7	42.2
Ажил эрхлэлт	51.4	52.6	44.2	54.8	59.3	54.3	61.1	48.6	50.0	39.4
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	59.4	50.0	42.1	48.8	39.5	43.0	38.6	41.4	45.7	50.0
Түүхий эд, материалын үнэ	92.2	85.7	85.7	83.8	82.5	76.2	76.9	84.4	90.0	81.5
Үйлчилгээний үнэ	66.7	70.0	70.2	59.8	63.1	58.9	68.5	71.4	77.9	62.1
Дуусаагүй ажил үйлчилгээ	53.7	83.3	48.7	63.2	62.8	59.8	61.9	59.3	55.6	47.9
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	65.3	59.7	61.5	65.0	67.5	62.0	57.4	57.6	65.6	46.8
Том										
Шинэ захиалга	55.0	52.8	53.3	70.0	62.5	65.0	66.7	57.1	66.7	57.1
Борлуулалтын орлого	72.7	59.5	68.8	61.1	56.3	69.0	83.3	68.8	66.7	50.0
Ажил эрхлэлт	63.6	52.6	43.8	58.8	43.8	61.9	66.7	50.0	58.3	44.4
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	27.8	45.0	57.1	55.9	50.0	42.1	50.0	50.0	33.3	43.8
Түүхий эд, материалын үнэ	80.0	85.0	78.6	83.3	87.5	77.5	50.0	71.4	75.0	92.9
Үйлчилгээний үнэ	72.7	71.4	75.0	75.0	68.8	59.5	33.3	75.0	75.0	81.3
Дуусаагүй ажил үйлчилгээ	44.4	67.6	65.4	69.2	50.0	55.9	33.3	41.7	62.5	71.4
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	77.3	55.3	68.8	73.3	68.8	61.9	83.3	71.4	58.3	61.1